МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 06 өдөр Дугаар А/324 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Сумын төвийн хогийн цэгийг дарж булах /Тариалан сум/" ажлын хүрээнд тус суманд нийлүүлэх хогны авто машин нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй байгаа тул холбогдох асуудлаар газар дээр нь шалгаж дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:
Б.Болд (Аймгийн орон нутгийн өмчийн газрын худалданавах ажиллагааны албаны дарга)

Гишүүдэд:
Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Г.Гантулга (Аймгийн авто тээврийн төвийн инженер)

Нарийн бичгийн дарга:
Х.Буянтогтох (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан 2023 оны 06 сарын 08-ны өдрийн дотор дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсэг (Б.Болд)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6712010656